



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 0/390

Хэрлэн сум

Хэлэлцүүлэг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 97, Хэнтий аймагт барилгын салбар үүсэж хөгжсөний 63 жилийн ойн хүрээнд “Хан Хэнтий 100 жил-Барилга бүтээн байгуулалт хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулахад 6,500,000 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

A/390

Аймгийн Засаг даргын 2023
оны 07 дугаар сарын 06-ны
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Оролцогчдын урилга хэвлүүлэх	ш	100	2,000.0	200,000.0
2	Оролцогчдын мандат хэвлүүлэх	ш	100	2,000.0	200,000.0
3	КН рестораны түрээсийн зардал	цаг	8	200,000.0	1,600,000.0
4	Үдийн цайны зардал (ус, кофе, печень)	Ш	100	7,500.0	750,000.0
5	Ус (0,5 л)	Ш	200	1,500.0	300,000.0
6	Дэвтэр	Ш	100	5,000.0	500,000.0
7	Бал	Ш	100	500.0	50,000.0
8	Инженерийн халаасны ном	Ш	100	29,000.0	2,900,000.0
					6,500,000.0